



**MONGOLIAN CASHMERE**

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

[www.gobicashmere.com](http://www.gobicashmere.com)

Улаанбаатар хот

2017 он

## АГУУЛГА

❖ Засаглалын үнэлгээний аргачлал . . . . .	3
❖ Засаглалын үнэлгээний нэгдсэн дүн . . . . .	4
❖ Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй дүн . . . . .	5
❖ Засаглалын үнэлгээнд хийсэн дүгнэлт . . . . .	15
❖ Цаашид компанийн засаглалыг сайжруулахад авах арга хэмжээ . . . . .	22

## ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Монголын хөрөнгийн биржээс батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга” буюу компани өөрийгөө үнэлэх асуулгыг ашиглан Засаглалын өөрийн үнэлгээг хийсэн.

Энэхүү үнэлгээний асуулт нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал
3. Оролцогч талууд
4. Ил тод нээлттэй байдал
5. Төлөөлөн удирдах зөвлөл
6. Гүйцэтгэх удирдлага гэсэн 6 үндсэн үзүүлэлт бүхий нийт 100 асуултаас бүрдсэн.

Асуулт бүрийн хүрээнд хийгдвэл зохих ажлын хэрэгжилтийг 0-2 оноогоор үнэлж түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

Энэхүү асуултууд нь хувьцаат компанийн зайлшгүй баримтлах ёстой сайн засаглалын нийтлэг зарчим, Монгол Улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Компанийн засаглалын кодексийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг үнэлэх зорилготой юм.

Засаглалын өөрийн үнэлгээг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хийсэн бөгөөд үнэлгээний үр дүнг 2017 оны 12 сарын 13-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэн, ТУЗ-ийн гишүүдийн саналыг тусган, ТУЗ-ийн дарга хянаж баталсан болно.

## ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Говь хувьцаат компанийн засаглалын өөрийн үнэлгээг дээрх аргачлалд дурдсан зургаан үндсэн үзүүлэлтийн хүрээнд боловсруулсан 100 асуултын хэрэгжилтэд үндэслэн 0-2 оноогоор үнэлж, асуулт бүрт авсан оноог хувьд шилжүүлэн гаргасан болно.

Хүснэгт 1. Говь ХК-ийн засаглалын үнэлгээний нэгдсэн дүн

№	Үндсэн зарчмууд	Асуултын тоо	Зорилтот үр дүн	Бодит үр дүн	Үр дүн /%/
А	Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал	20	20.0%	17.5%	87.5%
Б	Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал	10	10.0%	7.5%	75.0%
В	Оролцогч талууд	10	10.0%	8.0%	80.0%
Г	Ил тод нээлттэй байдал	20	20.0%	16.5%	82.5%
Д	Төлөөлөн удирдах зөвлөл	30	30.0%	24.5%	81.7%
Е	Гүйцэтгэх удирдлага	10	10.0%	7.5%	75.0%
	Нийт	100	100.0%	<b>81.5%</b>	

Хүснэгт 1-д үзүүлсэн нэгдсэн дүнгээс харахад Говь хувьцаат компанийн засаглалын нэгдсэн үнэлгээ нь 81.5% гарсан байна.

Үүнээс 80% ба түүнээс дээш хэрэгжилттэй байгаа үзүүлэлтүүд нь:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал
- Оролцогч талууд
- Ил тод нээлттэй байдал
- Төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой үйл ажиллагаа

Харин 80%-аас доош хэрэгжилттэй байгаа үзүүлэлтүүд нь:

- Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа гэсэн үр дүнтэй байна.

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ДҮН

Хүснэгт 2. Говь ХК-ийн засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй дүн

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар
<b>A</b>	<b>Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал</b>				Нийт 40 онооноос 35 оноо	
A.1	ХЭ-гчид компанийн засаглалын кодекст заасан үндсэн болон бусад эрхүүдийг бүрэн эдлэх нөхцөл боломжоор хангагдсан уу?			2	Компанийн дүрэм, холбогдох журмууд	КЗ-ийн кодексийн 2.1, 2.2, /Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйл/
A.2	Компанийн засаглалын кодекст заасан компанийн чухал асуудлуудыг ХЭХ-аар шийдвэрлэж байхаар дүрэмдээ тусгасан уу?			2	Компанийн дүрмийн заалтууд	КЗ-ийн кодексийн 4.1.2, 4.1.3, /КТХ-ийн 62 дугаар зүйл/
A.3	Компани хийж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянах боломж нөхцөлөөр ХЭ-гчдийг хангадаг уу?			2	Компанийн дүрмийн заалтууд	КТХ-ийн 62.1.10, 62.1.11, КЗ-ийн кодексийн 2.1, 4.1.3
A.4	ТУЗ-ийн гишүүний нэрийг дэвшүүлэх болон чөлөөлөх эрхийг хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр ХЭ-гчдийг хангасан уу?			2	Нэр дэвшүүлэх хорооны журам, хурлын материал	Компанийн тухай хууль 66 дугаар зүйл, 62.1.7, КЗ-ийн кодексийн 2.2.4, 4.1.3(vi)
A.5	ХЭ-гчид компанийг хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй юу?			2	Компанийн дүрэм болон журам	Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйл, КЗ-ийн кодексийн 2.2.6
A.6	Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг тодорхойлох журамтай юу?		1		Бодлогын баримт бичиг	КЗ-ийн кодексийн 2.2.2 а, б
A.7	Сүүлийн 3 жилд ногдол ашиг хуваарилсан уу?			2	ТУЗ-ийн шийдвэр, ХЭХ-ын хурлын тэмдэглэл, ногдол ашгийн тайлан	Сайн туршлага /Компанийн тухай хуулийн 46.15, 46.6/
A.8	ХЭХ-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор багтаан хуралдуулдаг уу?			2	ТУЗ-ийн шийдвэр, ХЭХ-ын тэмдэглэл, хурлын зар мэдээ, мэдэгдэл	Компанийн тухай хуулийн 59.4 дүгээр зүйл
A.9	ХЭХ-ыг зарлан хуралдуулах журамтай юу?	0			ХЭХ-ын журам	КЗ-ийн кодексийн 4.1.4, СЗХ-ны "Компанийн ХЭХ-ын үлгэрчилсэн журам"
A.10	ХЭХ-ын зарыг зохистой хэлбэрээр хүргэдэг үү?			2	Хурлын зар хүргэсэн баримтууд: e мэйл, мессеж, цахим хуудас, ТВ, сонин, радио зар	Компанийн тухай хуулийн 65 зүйл, СЗХ-ны "ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын 3 дугаар бүлэг
A.11	ХЭХ-ын материалыг зохистой хэлбэрээр хүргэж, хурлаар хэлэлцэх асуудлыг судалж танилцах нөхцөл бололцоогоор хангадаг уу?			2	ХЭХ-ын журам, хурлын товхимол, цахим хуудас	КЗ-ийн кодексийн 4.2, СЗХ-ны "ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын 3.7.4, 3.10

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар
A.12	Компанийн удирдах албаны хүмүүст олгосон шагнал урамшууллыг ХЭХ-д тайлагнаж хэлэлцдэг үү?			2	ХЭХ-ын журам, хурлын протокол	СЗХ-ны "Компанийн ХЭХ-ийн үлгэрчилсэн журам"-ын 2.1.15, КТХ-ийн 96.4.2
A.13	Компанийн саналын эрхтэй хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь ХЭХ-ын хөтөлбөрийн хэлэлцэх асуудалд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой юу?			2	Компанийн дүрэм, ХЭХ-ын журам, ХЭ-гчдээс ирүүлсэн санал	СЗХ-ны "Компанийн ХЭХ-ын үлгэрчилсэн журам"-ын 3 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйл
A.14	ХЭХ-ыг долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулдаг уу?			2	ХЭХ-ын журам, хурлын баримт материал	КЗ-ийн кодексийн 4.3.1, 4.3.2
A.15	Хурлаар хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулдаг уу?			2	Дүрэм, ХЭХ-ын журам, ХЭХ-ын протокол, шийдвэр	КЗ-ийн кодексийн 4.4.6, КТХ-ийн 63.3
A.16	ХЭ-гчид ХЭХ дээр хөндлөнгийн аудитороос асуулт асууж, тайлбар авах боломжоор хангагддаг уу?	0			Дүрэм, ХЭХ-ын журам, ХЭХ-ын протокол	Компанийн тухай хуулийн 94.12, СЗХ-ны "Компанийн ХЭХ-ийн үлгэрчилсэн журам"-ын 6.8.2
A.17	ХЭХ-д компанийн жилийн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, хэлэлцүүлэг хийх боломж олгодог уу?			2	Дүрэм, ХЭХ-ын журам, ХЭХ-ын протокол	КТХ-ийн 96 дугаар зүйл, СЗХ-ны "Компанийн ХЭХ-ийн үлгэрчилсэн журам"-ын 2.1.7, 2.1.15
A.18	ХЭ-гчдээс ХЭХ дээр асуулт тавьж хариулт авах хугацааг хурлын хэлэлцэх асуудалд оруулдаг уу?			2	ХЭХ-ын журам, хурлын хэлэлцэх асуудлын жагсаалт, ХЭХ-ын протокол	КЗ-ийн кодексийн 4.3.5, 4.3.6
A.19	ХЭХ-ын тооллогын комисс томилогдож, зохих журмын дагуу ажилладаг уу?			2	Дүрэм, ХЭХ-ын журам, ХЭХ-ын протокол, холбогдох шийдвэр	КТХ-ийн 67 дугаар зүйл, КЗ-ийн кодексийн 4.4
A.20	ХЭХ-ын тэмдэглэлийг хуульд заасан хугацаанд багтаан гаргаж хурлын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулдаг уу?			2	Дүрэм, ХЭХ-ын журам, хурлын тэмдэглэл	КЗ-ийн кодексийн 4.5, /КТХ-ийн 74.1 дүгээр зүйл/
<b>Б</b>	<b>Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал</b>				<b>Нийт 20 онооноос 15 оноо</b>	
Б.1	ХЭ-гчдийн гомдлыг хүлээж авах, барагдуулах асуудлыг холбогдох дүрэм журамд тусгасан уу?		1		Компанийн дүрэм, холбогдох журам,	Олон улсын сайн туршлага
Б.2	Ногдол ашгийг зохих бодлого журмын дагуу цаг хугацаанд нь ХЭ-гчдэд хялбар арга хэлбэрээр хуваарилдаг уу?			2	ТУЗ-ийн шийдвэр, ногдол ашгийн тайлан	КЗ-ийн кодексийн 2.2.2.в, д, е, Компанийн тухай хуулийн 46.10

№.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар	
Б.3	ХЭ-гч хүссэн тохиолдолд холбогдох мэдээллээр хангах асуудлыг холбогдох журамд тусгасан уу?		1		Мэдээллийн үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодексийн 7.3.1, 7.3.4, КТХ-ийн 65.6, 98 дугаар зүйл, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ын 4 дүгээр зүйл	
Б.4	ХЭХ-ын өмнө ХЭ-гч хүссэн тохиолдолд ХЭ-гчдийн бүртгэлтэй танилцах эрхтэй байх талаар журамд тусгасан уу?	0			ХЭХ-ын журам, мэдээллийн журам	СЗХ-ны “ХК-ийн хурлын үлгэрчилсэн журам”-ын 4.5	
Б.5	ХЭХ-аас гаргасан шийдвэрийг ХЭ-гчдэд танилцуулах нөхцөл боломжоор хангасан уу?			2	ХЭХ-ын журам, холбогдох бусад журам, цахим хуудас	КЗ-ийн кодексийн 4.4.7, КТХ-ийн 74.5, СЗХ-ны “ХК-ийн хурлын үлгэрчилсэн журам”-ын 8.14	
Б.6	ХЭХ хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш хурлын товыг өөрчлөхгүй байх талаар зохицуулсан зохицуулалтыг мөрдөж ажилладаг уу?			2		Компанийн тухай хуулийн 66.9, СЗХ-ны “ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам”-ын 2.4.	
Б.7	ХЭХ-д ХЭ-гч биеэр оролцож чадахгүй тохиолдолд хэрхэн санал өгөх талаар холбогдох журамд тодорхой тусгасан уу?			2	ХЭХ-ын журам, ХЭХ-ын зар, холбогдох шийдвэр	КЗ-ийн кодексийн 4.4.8, СЗХ-ны “Компанийн ХЭХ-ийн үлгэрчилсэн журам”-ын 4.18, 7.3, КТХ-ийн 68.4	
Б.8	ХЭ-гч мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан мэдээллийг цахимаар хүргүүлэх асуудал журамд тусгагдсан уу?		1		ХЭХ-ын журам, эсвэл санал авах тухай журам	Олон улсын сайн туршлага	
Б.9	Бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд шинэ эзэмшигчид ХЭХ-д оролцох итгэмжлэл олгох, эсхүл шинэ эзэмшигчийн өгсөн зааврын дагуу санал өгөх эрхийг хэрэгжүүлж ажилладаг уу?			2	Мэдээллийн үйл ажиллагааны тухай журам	Компанийн тухай хуулийн 68.5, СЗХ-ны “Компанийн ХЭХ-ийн үлгэрчилсэн журам”-ын 4.6, 4.7	
Б.10	ХЭ-гчдийн ээлжит хурлын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн цахим хаягаар хүргэдэг үү?			2	ХЭХ-ын журам, ХЭХ-ын баримт бичиг	СЗХ-ны “ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам”-ын 3.5, Олон улсын сайн туршлага	
<b>В</b>	<b>Оролцогч талууд</b>					<b>Нийт 20 онооноос 16 оноо</b>	
В.1	Компанид оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан бодлого, журам байдаг уу?	0			Бодлого, журам, гэрээ	КЗ-ийн кодексийн 10 дугаар бүлэг	
В.2	Оролцогч талуудын санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах механизм бий юу?		1		Холбогдох бодлого журам	КЗ-ийн кодексийн 10 дугаар бүлэг	

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар
B.3	Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТУЗ-тэй шууд холбоо барих механизм бий юу?		1		Бодлогын баримт бичиг	КЗ-ийн кодексийн 10 дугаар бүлэг
B.4	Компани гаргаж буй шийдвэрүүдээ оролцогч талуудын сонирхол, эрх ашгийг харгалзан гаргадаг уу?			2	Тогтоол, шийдвэрүүд, өргөдөл гомдлын бүртгэл	КЗ-ийн кодексийн 10.1
B.5	Компани нь оролцогч талуудыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилладаг уу?			2	Компанийн цахим хуудас /цахим хуудас нь ХЭ-гчид болон оролцогч талуудтай харилцах боломжийг хангасан байх/	КЗ-ийн кодексийн 10.2, 10.4
B.6	Компани оролцогчидтой гэрээ байгуулах явцад нь хяналт тавих, дүгнэх, хариуцлага тооцох үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	Холбогдох журам	КЗ-ийн кодексийн 10.3, Олон улсын сайн туршлага
B.7	Компанийн бэлтгэн нийлүүлэгчид, худалдан авагчид, гэрээ гүйцэтгэгч зэрэг гол гол харилцагч талуудын хэдэн хувь нь 3-аас дээш жил хамтарсан түншүүд байдаг вэ?			2	Холбогдох гэрээ болон бусад баримт	Олон улсын сайн туршлага
B.8	Компани нь оролцогч талуудтай холбоотой чухал үйл явдал /томоохон түншээ алдах, гэрээ цуцлагдах г.м/-ын мэдээллийг ХЭ-гч, ХО-гчдад мэдээлдэг үү?			2	Жилийн тайлан, компанийн цахим хуудас, мэдээллийн журам	СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ын 3.2.10, 3.2.7-3.2.9, КЗ-ийн кодексийн 10.6
B.9	Компанийн ажилтнуудын санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, тэдний нийгмийн асуудал, мэргэжил мэргэшлийг дээшлүүлэх төлөвлөгөөтэй ажилладаг уу?			2	Бодлогын бичиг баримт, төлөвлөгөө, хөтөлбөр, хөдөлмөрийн гэрээ	КЗ-ийн кодексийн 10.5
B.10	Компани дотооддоо үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай байх бодлогыг дэмжиж ажилладаг уу?			2	Компанийн стратеги, түүний төлөвлөгөө, бусад бодлогын баримт бичиг	Олон улсын сайн туршлага
<b>Г</b>	<b>Ил тод нээлттэй байдал</b>				<b>Нийт 40 онооноос 33 оноо</b>	
G.1	Компани мэдээллийн журамтай юу?	0			Компанийн дүрэм, Мэдээллийн үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодексийн 7.3.1, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ын 4 дүгээр зүйл



No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар
Г.2	Хөрөнгө оруулагчтай харилцах болон нийтэд мэдээлэл хүргэх зохистой тогтолцоог бүрдүүлсэн үү?			2	Компанийн цахим хуудас, ХЭ-гчдийн болон зорилтот бүлгийн цахим хаяг, ХЭХ-д зориулсан товхимол, Мэдээллийн журам	КЗ-ийн кодекс 7.3, КТХ-ийн 98 дугаар зүйл, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг тогтмол хүргэх тухай журам”-ын 4 дүгээр зүйл
Г.3	Хувьцаа эзэмшигчидтэй харилцах, нийтэд мэдээлэл түгээх, СЗХ болон МХБ-ээс тогтоосон журмын дагуу мэдээллийг тогтмол хүргэх чиг үүрэг бүхий ажилтантай юу?			2	Мэдээллийн журам, ажлын байрны тодорхойлолт, удирдлагын шийдвэр	КТХ-ийн 82.2.1, МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 17.6, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд хүргэх тухай журам”-ын 3.4
Г.4	ТУЗ-ийн болон компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмыг өөрийн цахим хуудас дээр байршуулан нийтэд мэдээлж ажилладаг уу?			2	Мэдээллийн бодлого, холбогдох журмууд, Компанийн цахим хуудас	КЗ-ийн кодексийн 7.3.4
Г.5	Компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж чадсан уу?			2	Компанийн цахим хуудас, холбогдох журам	МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.3, “ХК өөрийн цахим хуудсанд ХЭ-гч, хөрөнгө оруулагчдад зориулсан цэстэй байх тухай зөвлөмж”, олон улсын сайн туршлага
Г.6	ХЭ-гчдийн ээлжит хурлын зар мэдэгдлийг СЗХ, МХБ болон ХЭ-гчдэд цаг хугацаанд нь хүргүүлсэн үү?			2	МХБ, ХК-ийн цахим хуудас, мэдээллийн бусад хэрэгсэл	СЗХ-ны “ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам”-ын 2.6, КЗ-ийн кодексийн 4.2.5, МХБ-ийн Бүртгэлтэй компаниудаас мэдээлэл ирүүлэх зааврын 8.1
Г.7	ХЭ-гчдийн ээлжит хурлын шийдвэрийг СЗХ, МХБ болон ХЭ-гчдэд цаг хугацаанд нь хүргүүлсэн үү?			2	МХБ, ХК-ийн цахим хуудас, холбогдох баримт	ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 56.1.6, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх журам”-ын 3.2.28, МХБ-ийн Бүртгэлтэй компаниудаас мэдээлэл ирүүлэх зааврын 8.2
Г.8	Компани олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж, мөрдөн ажилладаг уу?			2	Холбогдох баримт бичиг, тайлагнах зарчим	КЗ-ийн кодекс 7.1, МХБ-ийн Бүртгэлийн журмын 17.3

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар
Г.9	Компанийн санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд гарган СЗХ, МХБ-д хүргүүлж, нийтэд мэдээлдэг үү?			2	МХБ, ХК-ийн цахим хуудас, санхүүгийн тайлангууд	ҮЦЗЗ-ийн тухай хуулийн 20.1.6, МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.4.1, 18.4.2
Г.10	Жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох хууль журмын дагуу гаргаж мэдээлдэг үү?			2	МХБ, ХК-ийн цахим хуудас, хэвлэмэл материал	КЗ-ийн кодексийн 7.3.3, КТХ-ийн 96.4, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх журам”-ын 2.4, 2.5, МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.4.1.2.3
Г.11	Жилийн үйл ажиллагааны тайланд компанийн (санхүүгийн бус) үйл ажиллагаа, түүний өрсөлдөх чадвар ямар байгаа болон бусад санхүүгийн холбогдолгүй асуудлын талаар тодорхой тусгадаг уу?			2	Жилийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн дүгнэлт, ХЭХ-ын материал	КЗ-ийн кодексийн 7.3.2, “Жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэх тухай зөвлөмж” олон улсын сайн туршлага
Г.12	Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл ил тод байдаг уу?			2	Мэдээллийн журам, МХБ, ХК-ийн цахим хуудас	ҮЦЗЗ-ийн тухай хууль 56.1.2, МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.4.6
Г.13	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын хувьцааны эзэмшлийн талаарх мэдээлэл ил тод байдаг уу?			2	Мэдээллийн журам, МХБ, ХК-ийн цахим хуудас	ҮЦЗЗ-ийн тухай хууль 56.2.5, МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.4.5
Г.14	Тухайн жилийн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцлийн талаар нийтэд мэдээлдэг үү?			2	Мэдээллийн журам, улирал, жилийн тайлан	Компанийн тухай хуулийн 88.4, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд хүргэх тухай журам”-ын 3.2.15
Г.15	Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?		1		ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн журам, Жилийн тайлан	КЗ-ийн кодекс 7.3.2, 8.1.2(ii), 9.1-9.3, КТХ-ийн 81.4.1
Г.16	Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?			2	Мэдээллийн журам, Жилийн тайлан	КТХ-ийн 96.4.2, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд хүргэх тухай журам”-ын 2.5.1
Г.17	Компанийн засаглалын тайлан, КЗ-ын кодексийг хэрэгжүүлж байгаа эсэх тухай мэдэгдлийг жилийн үйл ажиллагааны тайланд тусгадаг уу?			2	Мэдээллийн журам, Жилийн тайлан	МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.4.1.2.3, олон улсын сайн туршлага

No.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар	
Г.18	Компанийн чухал үйл явдал, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг тухай бүр шуурхай хүргэх талаар холбогдох журамд тусгаж, хэрэгжүүлдэг үү?		1		Мэдээллийн журам, холбогдох баримтууд, МХБ, ХК-ийн цахим хуудас	КЗ-ийн кодексийн 7.3, СЗХ-ны “ҮЦГ-аас мэдээллийг тогтмол хүргэх тухай журам”-ын 3 дугаар зүйл, МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.4.4	
Г.19	Компани дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийж байгаа эсэхэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн үү?		1		Мэдээллийн журам, дотоод хяналтын журам, компанийн ЭБАТ-ны жагсаалт	КЗ-ийн кодекс 7.3.5, СЗХ-ны “Үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагааны тухай журам”	
Г.20	Хөндлөнгийн аудиторыг хугацаанаас нь өмнө сольсон тохиолдолд энэ талаар нийтэд мэдээлэх тухай холбогдох журамд тусгаж ажилладаг уу?	0			Холбогдох журмууд, МХБ-ийн болон өөрийн цахим хуудас	КЗ-ийн кодексийн 7.2.5	
<b>Д</b>	<b>Төлөөлөн удирдах зөвлөл</b>					<b>Нийт 60 онооноос 49 оноо</b>	
Д.1	ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?	0			ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодекс 5.1.4, КТХ-ийн 76.1.13, СЗХ-ны “ТУЗ-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам”	
Д.2	ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлсон уу?		1		Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодексийн 5.1, 9.1, СЗХ-ны “ТУЗ-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам”	
Д.3	ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, удирдамж зөвлөмжөөр хангаж ажилладаг уу?			2	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл	КЗ-ын кодексийн 5.1.2	
Д.4	ТУЗ-ийн даргыг компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс сонгохгүй байх зохицуулалтыг холбогдох журамд тусгасан уу?		1		ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	СЗХ-ны “Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам”-ын 7.2, КТХ-ийн 83.4, КЗ-ын кодексийн 5.2.5	
Д.5	ТУЗ-ийн бүрэлдэхүүн хангалттай тооны хараат бус гишүүдтэй юу?			2	ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл	КЗ-ын кодексийн 5.2.3, 5.2.6	
Д.6	ТУЗ-ийн хурлын жилийн төлөвлөгөө гаргаж ажилладаг уу?			2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын төлөвлөгөө	КТХ-ийн 80.1, СЗХ-ны “ТУЗ-ийн ажиллагааны үлгэрчилсэн журам”	
Д.7	ТУЗ-ийн гишүүд ХЭХ-д биечлэн оролцож, ХЭ-гчдийн асуултад хариулт өгдөг байх үүргийг холбогдох журамд тусгасан уу?		1		ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	Олон улсын сайн туршлага, КЗ-ийн кодексийн 5.4.2	
Д.8	Хамгийн сүүлийн ХЭХ-д ТУЗ-ийн гишүүдийн хэдэн хувь оролцсон бэ?		1		ХЭХ-ын тэмдэглэл	90%-иас дээш оролцсон бол 2 оноо, 33.3%-иас доош бол 0 оноо, бусад 1 оноо	

№.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар
Д.9	Орон тооны ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай юу?			2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /НБД/-ыг томилсон шийдвэр	СЗХ-ны “Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үлгэрчилсэн журам”-ын 2.4
Д.10	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлага нь тодорхой байдаг уу?			2	ТУЗ-ийн НБД-ын үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодексийн 5.9, КТХ-ийн 82.2, 98.2, СЗХ-ны “Компанийн ТУЗ-ийн НБД-ын үлгэрчилсэн журам”-ын 1.2.
Д.11	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал нь бусад эрх бүхий албан тушаалтныхтай ижил хэмжээнд тогтоогдсон уу?		1		Тогтоол, шийдвэр	Олон улсын сайн туршлага
Д.12	ТУЗ-ийн дэргэд нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороотой юу?			2	Хороодын үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодексийн 5.5, КТХ-ийн 81 дүгээр зүйл
Д.13	Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?			2	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны журам	СЗХ-ны “ТУЗ-ийн нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны үлгэрчилсэн журам”-ууд
Д.14	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх үйл ажиллагаа нь зохих журмын дагуу явагддаг уу?			2	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам	КЗ кодексийн 5.6, КТХ-ийн 81.5, СЗХ-ны “ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны үлгэрчилсэн журам”-ын 2 дугаар зүйл
Д.15	ТУЗ-д нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдээс сонголт хийх, санал хураах асуудлыг журамд бүрэн, ойлгомжтой тусгаж, журмаа ил тод болгосон уу?			2	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Нэр дэвшүүлэх хорооны журам	КЗ кодексийн 5.6.5-5.6.6 дахь заалт, СЗХ-ны “ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны үлгэрчилсэн журам”
Д.16	Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын бодлоготой юу?			2	Компанийн дүрэм, хүний нөөцийн үйл ажиллагааны журам, цалин урамшууллын хорооны хурлын материал, холбогдох бодлого, журам	КЗ кодексийн 5.6, КТХ-ийн 81.6, СЗХ-ны “Цалин урамшууллын хорооны үлгэрчилсэн журам”-ын 2 дугаар зүйл
Д.17	ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг үнэлж дүгнэдэг үү?			2	ТУЗ-ийн шийдвэр, холбогдох журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэсэн тухай тайлан	КЗ-ын кодексийн 5.6.2, СЗХ-ны “Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам”-ын 13.1, СЗХ-ны Компанийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны үлгэрчилсэн журмын 2.2


№.	Асуулт	Үгүй 0	Зарим 1	Бүрэн 2	Нотлох баримт	Хууль, дүрэм журмын тайлбар
Д.18	Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын хэмжээг тогтоодог уу?		1		ТУЗ-ийн шийдвэр, холбогдох журам	КЗ-ийн кодексийн 5.6.2 дахь заалт, СЗХ-ны "Компанийн ТУЗ-ийн цалин урамшууллын хорооны үлгэрчилсэн журам"-ын 2.1
Д.19	ТУЗ-ийн дэргэд Аудитын хороотой юу?			2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодексийн 5.5, 5.7, СЗХ-ны "ТУЗ-ийн аудитын хорооны үлгэрчилсэн журам"
Д.20	Аудит, цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны дарга нь хараат бус гишүүн байдаг уу?			2	Хороо байгуулах тухай ТУЗ-ийн шийдвэр, ХЭХ-ын тэмдэглэл, тогтоол	КЗ-ийн кодексийн 5.5.4, КТХ-ийн 81.2, 81.4
Д.21	Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайланг нягтлан шалгасан талаар дүнг хэлэлцэж дүгнэлт өгдөг үү?			2	Аудитын хорооны шийдвэр, хурлын тэмдэглэл	СЗХ-ны "Компанийн аудитын хорооны үлгэрчилсэн журам"-ын 2.1.2.3, 2.1.2.4, 2.1.2.5, КТХ 81.4.1
Д.22	Аудитын хороо нь компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгсөн үү?			2	Аудитын хорооны шийдвэр, хурлын тэмдэглэл	СЗХ-ны "Компанийн ТУЗ-ийн аудитын хорооны үлгэрчилсэн журам"-ын 2.1.1, КЗ-ын кодексийн 8, 9 дүгээр бүлэг
Д.23	ТУЗ-өөс томилогддог дотоод аудитын албатай юу?			2	ТУЗ-ийн холбогдох шийдвэр	КЗ-ын кодексийн 8.1.3, 8.1.4
Д.24	Дотоод аудитын албаны тайланг ТУЗ хэлэлцэж, дүгнэлт гаргасан уу?			2	ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр	КЗ-ын кодексийн 8.1.2(vi)
Д.25	Хөндлөнгийн аудиторыг сонгох ажиллагааг зохицуулах бодлого журамтай юу?			2	Компанийн дүрэм, бодлого журам	КЗ-ийн кодексийн 7.2.3
Д.26	Аудитын хороо нь хөндлөнгийн аудиторыг нэр дэвшүүлж ТУЗ-д танилцуулж ажилладаг уу?			2	Аудитын хорооны шийдвэр, хурлын тэмдэглэл	КЗ-ийн кодексийн 5.7.2, СЗХ-ны ТУЗ-ийн аудитын хорооны үлгэрчилсэн журмын 2.1.3
Д.27	Хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулсан байдал, түүний бие даасан, хараат бус байдлыг батлах баримт мэдээллийг ХЭХ-д танилцуулдаг уу?			2	Аудитын хорооны болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр, ХЭХ-ын протокол	КЗ-ийн кодексийн 7.2, Компанийн ТУЗ-ийн аудитын хорооны үлгэрчилсэн журмын 2.1.3.2, сайн туршлага
Д.28	ТУЗ-ийн хороо бүр тогтмол хуралддаг уу?			2	Хороодын хурлын тэмдэглэл	СЗХ-ны ТУЗ-ийн хороо тус бүрийн үлгэрчилсэн журам /5.3, 5.4/
Д.29	ТУЗ-ийн хороо бүр тайлан гаргадаг уу?		1		Үйл ажиллагааны тайлан, ТУЗ-д тайлагнасан тэмдэглэл	Олон улсын сайн туршлага, СЗХ-ны ТУЗ-ийн хороодын үлгэрчилсэн журам 3.3
Д.30	ТУЗ-ийн ёс зүйн кодексийг батлан мөрддөг үү?	0			ТУЗ-ийн шийдвэр, холбогдох журам	КЗ-ийн кодексийн 5.8.1

E	Гүйцэтгэх удирдлага				Нийт 20 онооноос 15 оноо	
E.1	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг зохицуулсан тусгай журам заавартай юу?	0			Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам, Компанийн дүрэм	КТХ-ийн 76.1.13, СЗХ-ны "... ХК-ийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ерөнхий заавар"
E.2	Гүйцэтгэх удирдлага холбогдох журмын дагуу үйл ажиллагааны үр дүнг тогтмол тайлагнадаг уу?			2	Гүйцэтгэх удирдлагын тайлан	СЗХ-ны "... ХК-ийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ерөнхий заавар"-ын 3.3.12-3.3.14, 6.6.
E.3	ТУЗ-өөс удирдлагын багийн үйл ажиллагааг үнэлэх дүгнэх журмыг боловсруулсан уу?			2	ТУЗ-ийн шийдвэр, холбогдох дүрэм журам, гэрээ, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	КЗ-ийн кодексийн 5.6.4, Компанийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны үлгэрчилсэн журмын 2.2.1
E.4	Компани дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын бодлоготой юу?			2	ТУЗ-ийн шийдвэр, хурлын тэмдэглэл, бодлогын баримт бичиг	КЗ-ын кодексийн 8 дугаар бүлэг, 9.2, 9.3 дахь заалт
E.5	Гүйцэтгэх удирдлага сонирхлын зөрчил бүхий аливаа үйл ажиллагаанаас зайлсхийх талаар зохицуулсан зохицуулалтыг холбогдох дүрэм, журамд тусгасан уу?		1		Холбогдох журам	КЗ-ын кодексийн 6.1.3, СЗХ-ны "... ХК-ийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ерөнхий заавар"-ын 6 дугаар зүйл
E.6	Нийтэд нээлттэй бус дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, задруулахыг хориглох хяналт зохицуулалтыг хэрэгжүүлдэг үү?			2	Холбогдох журам	СЗХ-ны "... ХК-ийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ерөнхий заавар"-ын 6.3, 6.4, СЗХ-ны "Үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагааны тухай журам"-ын 4-р зүйл
E.7	Гүйцэтгэх удирдлагын тухайн компанийн үнэт цаасны арилжаанд оролцож буй байдлыг ил тод болгодог уу?			2	Холбогдох журам	Олон улсын сайн туршлага, ҮЦЗЗТХ-ийн 56.2.5, 56.3, МХБ-ийн Бүртгэлийн журмын 18.4.5.1
E.8	Компани ёс зүйн дүрэмтэй юу?		1		ТУЗ-ийн шийдвэр, холбогдох дүрэм	КЗ-ын олон улсын сайн туршлага
E.9	Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг нийтэд мэдээлдэг үү?			2	Компанийн цахим хуудас, жилийн тайлан	Компанийн тухай хуулийн 96.4.2
E.10	Удирдлагын залгамж халааны бодлоготой юу?		1		Залгамж халааны бодлого	КЗ-ын кодексийн 5.6.7

## ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Хүснэгт 2-ын Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй дүнг үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

**А. Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал**



Нийт 20 асуулттай бөгөөд 40 оноо авбал зохицоос 35 оноо авсан буюу 87.5% хэрэгжилттэй байна.

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

2 оноо авсан буюу бүрэн хэрэгждэг-17,

1 оноо авсан буюу зарим нь хэрэгждэг-1,

0 оноо авсан буюу хэрэгждэггүй-2 асуулт байна.

**Зарим нь хэрэгждэг:**

**А.6. Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг тодорхойлох журамтай юу?**

- Ногдол ашгийн батлагдсан бодлого байхгүй ч ТУЗ-ийн хурлаар жил бүрийн цэвэр ашгаас 10 орчим хувийг ногдол ашигт олгож байхаар хэлэлцсэн.


**Хэрэгждэггүй:**

**А.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журамтай юу?**

- Компанид батлагдсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” байхгүй ч Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ыг дагаж мөрдөн, хувьцаа эзэмшигч нарыг эрх ашгийг дээдлэн, үйл ажиллагаагаа явуулдаг. Цаашид “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг боловсруулан батлах шаардлагатай.

**А.16. Хувьцаа эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хөндлөнгийн аудиторос асуулт асууж, тайлбар авах боломжоор хангагддаг уу?**

- Компанийн жилийн үйл ажиллагааны тайландаа хөндлөнгийн аудиторын дүгнэлт, тайланг нийтэд ил тодоор нийтэлдэг. Харин хувьцаа эзэмшигчийн хурал дээр хөндлөнгийн аудиторын төлөөллөөс оролцдоггүй. Цаашид дараа дараагийн хурал дээр хөндлөнгийн аудиторын төлөөллөөс оролцуулдаг байх дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

**Б. Хувьцаа эзэмшигчдийн ижил тэгш байдал**

Нийт 10 асуулттай бөгөөд 20 оноо авбал зохицоос 15 оноо авсан буюу 75% хэрэгжилттэй байна.

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

2 оноо авсан буюу бүрэн хэрэгждэг- 6,

1 оноо авсан буюу зарим нь хэрэгждэг- 3,

0 оноо авсан буюу хэрэгждэггүй- 1 асуулт байна.

**Зарим нь хэрэгждэг:**

**Б.1. Хувьцаа эзэмшигчдийн гомдлыг хүлээж авах, барагдуулах асуудлыг холбогдох дүрэм журамд тусгасан уу?**

- Компанид батлагдсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам” байхгүй ч Хөдөлмөрийн дотоод журамд иргэд, байгууллагаас ирсэн хүсэлт, гомдлыг шийдвэрлэх тухай заасан байдаг.

**Б.3. Хувьцаа эзэмшигч хүссэн тохиолдолд холбогдох мэдээллээр хангах асуудлыг холбогдох журамд тусгасан уу?**

- Компанид батлагдсан “Мэдээллийн үйл ажиллагааны журам” байхгүй ч, Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг дагаж мөрдөн, хувьцаа эзэмшигч нарыг мэдээллээр тухай бүр хангах үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа.

**Б.8. Хувьцаа эзэмшигч мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан мэдээллийг цахимаар хүргүүлэх асуудал журамд тусгагдсан уу?**


- Компанид батлагдсан “Мэдээллийн үйл ажиллагааны журам” байхгүй ч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хувьцаа эзэмшигчдээс ирсэн цахим шууданд цаг алдалгүй түргэн шуурхай хариу өгч, мэдээллээр ханган ажилладаг. Цаашид “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан батлах шаардлагатай.

**Хэрэгждэггүй:**

**Б.4. Хувьцаа эзэмшигчийн хурлын өмнө хувьцаа эзэмшигч хүссэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн бүртгэлтэй танилцах эрхтэй байх талаар журамд тусгасан уу?**

- Компанид батлагдсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам” байхгүй тул энэ талаар журамд тусгагдаагүй. Цаашид “Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ыг батлах хэрэгтэй.



**В. Оролцогч талууд**

Нийт 10 асуулттай бөгөөд 20 оноо авбал зохицоос 16 оноо авсан буюу 80% хэрэгжилттэй байна.

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

2 оноо авсан буюу бүрэн хэрэгждэг- 7,

1 оноо авсан буюу зарим нь хэрэгждэг- 2,

0 оноо авсан буюу хэрэгждэггүй- 1 асуулт байна.

**Зарим нь хэрэгждэг:**

*В.2. Оролцогч талуудын санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах механизм компанид бий юу?*

- Компанид батлагдсан “Оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалсан журам” байхгүй ч Хөдөлмөрийн дотоод журамд иргэд, байгууллагаас ирсэн хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай тодорхой заасан байдаг.

*В.3. Компанийн хэмжээнд гарч буй хууль бус болон ёс зүйгүй практик ажиллагааны талаар ТУЗ-тэй шууд холбоо барих механизм бий юу?*


- Компанид албан ёсоор батлагдсан бодлого, журам байхгүй ч, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтэс үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хараат бус байдлаар компанийн хэмжээнд хяналт шалгалтыг тогтмол хийн, үүссэн зөрчил, эрсдэлийн талаар ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд тайлагнан ажилладаг.

**Хэрэгждэггүй:**

*В.1. Компанид оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан бодлого, журам байдаг уу?*

- Компанид батлагдсан “Оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалсан журам” байхгүй тул цаашид энэхүү журмыг батлах хэрэгтэй.

## Г. Ил тод нээлттэй байдал



Нийт 20 асуулттай бөгөөд 40 оноо авбал зохицоос 33 оноо авсан буюу 82.5% хэрэгжилттэй байна.

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

2 оноо авсан буюу бүрэн хэрэгждэг- 15,

1 оноо авсан буюу зарим нь хэрэгждэг- 3,

0 оноо авсан буюу хэрэгждэггүй- 2 асуулт байна.

**Зарим нь хэрэгждэг:**

Г.15. Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг жилийн тайланд тусгадаг уу?

- Жилийн үйл ажиллагааны тайланд компанийн Эрсдэлийн удирдлагын багийн үйл ажиллагааны талаар тусгадаг. Эрсдэлийн удирдлагын баг нь компанийн хэмжээнд учирч болох эрсдэлүүдийг тогтмол илрүүлэн, арга хэмжээ авч ажилладаг бөгөөд үр дүнгээ ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороонд тайлагнадаг. Цаашид компанийн жилийн үйл ажиллагааны тайланд учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тусгах хэрэгтэй.

Г.18. Компанийн чухал үйл явдал, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг тухай бүр шуурхай хүргэх талаар холбогдох журамд тусгаж, хэрэгжүүлдэг үү?

- Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг дагаж мөрдөн, чухал үйл явдал болон үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг тухай бүр олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа.

Г.19. Компани дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийж байгаа эсэхэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн үү?

- Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн үнэт цаасны зах зээлд дээр явуулах үйл ажиллагааны тухай журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

**Хэрэгждэггүй:**


*Г.1. Компани мэдээллийн журамтай юу?*

- Компанид батлагдсан “Мэдээллийн үйл ажиллагааны журам” байхгүй тул цаашид энэхүү журмыг боловсруулан баталж, дагаж мөрдөх шаардлагатай.

*Г.20. Хөндлөнгийн аудиторыг хугацаанаас нь өмнө сольсон тохиолдолд энэ талаар нийтэд мэдээлэх тухай холбогдох журамд тусгаж ажилладаг уу?*

- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооноос “Хараат бус аудитын компанид тавигдах шаардлага”-ыг баталсан бөгөөд энэхүү шаардлагын дагуу хараат бус аудиторыг сонгон шалгаруулдаг. Харин хугацаанаас нь өмнө хөндлөнгийн аудиторыг сольсон тохиолдолд олон нийтэд мэдээлэх талаар журамд тусгагдаагүй байгаа. Цаашид “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан, энэ талаар тусгах шаардлагатай.

**Д. Төлөөлөн удирдах зөвлөл**



Нийт 30 асуулттай бөгөөд 60 оноо авбал зохихоос 49 оноо авсан буюу 81.7% хэрэгжилттэй байна.

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

2 оноо авсан буюу бүрэн хэрэгждэг- 21,

1 оноо авсан буюу зарим нь хэрэгждэг- 7,

0 оноо авсан буюу хэрэгждэггүй- 2 асуулт байна.

**Зарим нь хэрэгждэг:**

*Д.2. ТУЗ-ийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлсон уу?*

- Компанид батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” байхгүй ч, Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

*Д.4. ТУЗ-ийн даргыг компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс сонгохгүй байх зохицуулалтыг холбогдох журамд тусгасан уу?*

- Компанид батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” байхгүй ч, Компанийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн, ТУЗ-ийн даргаар үргэлж хараат бус гишүүнийг сонгон ажиллуулдаг.

*Д.7. ТУЗ-ийн гишүүд Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт өгдөг байх үүргийг холбогдох журамд тусгасан уу?*

- Холбогдох журамд тусгагдаагүй ч жил бүр Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн хараат бус гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцдог.

*Д.8. Хамгийн сүүлийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн гишүүдийн хэдэн хувь оролцсон бэ?*

- 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн гишүүдийн 78% оролцсон.

*Д.11. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал нь бусад эрх бүхий албан тушаалтныхтай ижил хэмжээнд тогтоогдсон уу?*

- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 2017 оны 1 сараас эхлэн солигдсон бөгөөд шинэ нарийн бичгийн даргын хувьд компанийн засаглалын чиглэлээрх мэдлэг туршлагаа улам бүр сайжруулан, хөгжүүлэх шаардлагатай байгаа.

*Д.18.Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын хэмжээг тогтоодог уу?*

- Жил бүр ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийн үйл ажиллагааг цогцоор нь үнэлэх өөрийн үнэлгээг хийдэг. Энэхүү өөрийн үнэлгээ нь ТУЗ-ийн зохион байгуулалттай холбоотой шалгуурууд, ТУЗ-ийн зорилго, зорилтуудтай холбоотой шалгуурууд гэсэн үндсэн 2 шалгуур үзүүлэлт, 7 бүлэг бүхий 25 асуултаас бүрдэх бөгөөд ТУЗ-ийн гишүүн бүр өөрсдөө үнэлгээг хийдэг. Харин хараахан ТУЗ-ийн гишүүн бүрт үнэлгээ өгч, урамшууллын хэмжээг нь тогтоох систем рүү шилжээгүй байгаа.

*Д.29. ТУЗ-ийн хороо бүр тайлан гаргадаг уу?*

- ТУЗ-ийн дэргэдэх хороод тогтмол хурлаа зохион байгуулж, үйл ажиллагааныхаа чиг үүргийн хүрээнд санал зөвлөмж, шийдвэрийг гарган ТУЗ-д танилцуулдаг бөгөөд жилд нэг удаа ТУЗ-д үйл ажиллагааны тайлангаа танилцуулдаг байхаар дүрэмдээ заасан байдаг. Цаашид хороод үйл ажиллагааны тайлангаа ТУЗ-д тогтмол тайлагнадаг болох хэрэгтэй.

### **Хэрэгждэггүй:**

*Д.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохицуулсан журамтай юу?*

- Компанид батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам” байхгүй тул цаашид энэхүү журмыг батлах шаардлагатай.

*Д.30. ТУЗ-ийн ёс зүйн кодексийг батлан мөрддөг үү?*

- Компанид батлагдсан “ТУЗ-ийн ёс зүйн кодекс” байхгүй тул цаашид боловсруулан баталж, мөрдөх шаардлагатай.

**Е. Гүйцэтгэх удирдлага**

Нийт 10 асуулттай бөгөөд 20 оноо авбал зохицоос 15 оноо авсан буюу 75% хэрэгжилттэй байна.

Асуултуудыг задаргаагаар нь авч үзвэл:

2 оноо авсан буюу бүрэн хэрэгждэг- 6,

1 оноо авсан буюу зарим нь хэрэгждэг- 3,

0 оноо авсан буюу хэрэгждэггүй- 1 асуулт байна.

**Зарим нь хэрэгждэг:**

*Е.5. Гүйцэтгэх удирдлага сонирхлын зөрчил бүхий аливаа үйл ажиллагаанаас зайлсхийх талаар зохицуулсан зохицуулалтыг холбогдох дүрэм, журамд тусгасан уу?*

- Батлагдсан “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам” байхгүй ч сонирхлын зөрчил бүхий аливаа үйл ажиллагаанаас сэргийлэх зорилгоор харилцагч гүйцэтгэгчтэй 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гэрээ хэлцэл хийх үед компанийн үнэлгээний хороогоор хэлэлцэн шийдвэрлэдэг байхаар дотоод журамд тусгасан.

*Е.8. Компани ёс зүйн дүрэмтэй юу?*

- Батлагдсан ёс зүйн дүрэм байхгүй ч, Хөдөлмөрийн дотоод журамд ёс зүйн хэм хэмжээний талаар заасан байдаг.

*Е.10. Удирдлагын залгамж халааны бодлоготой юу?*

- Албан ёсоор батлагдсан бодлого байхгүй ч Хүний нөөцийн хэлтсийн зүгээс компанийн түлхүүр ажлын байрууд болон онцлох ажлын байруудыг тодорхойлж, үйлдвэрлэлийн шат дамжлагын онцлог ур чадварыг эзэмшсэн ажлын байрууд дээр залгамж халааг бэлтгэн хөгжүүлэх дээр анхааран ажилладаг.

**Хэрэгждэггүй:**

*Е.1. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг зохицуулсан тусгай журам заавартай юу?*

- “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам” байхгүй тул цаашид боловсруулан батлах шаардлагатай.

## ЦААШИД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХАД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Говь ХК-ийн засаглалын өөрийн үнэлгээг хийхэд 81.5% үр дүнтэй гарсан. Манай компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд сайн засаглалыг хэрэгжүүлэн, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорьж ажилладаг. Энэ ч утгаараа бидэнд хийж сайжруулах зүйлс нэлээд байгааг илтгэсэн үр дүн гарлаа хэмээн дүгнэж байна. Иймд бид цаашид компанийн засаглалаа улам илүү сайжруулахын тулд дараах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- ❖ Ногдол ашгийн бодлоготой болох
- ❖ Хувьцаа эзэмшигчдийн хурлын журамтай болох
- ❖ Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
- ❖ ТУЗ-ийн үйл ажиллагааны журамтай болох
- ❖ Мэдээллийн үйл ажиллагааны журамтай болох
- ❖ Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журамтай болох
- ❖ Оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалсан журамтай болох
- ❖ Компанийн ёс зүйн дүрэмтэй болох
- ❖ ТУЗ-ийн ёс зүйн кодекстой болох
- ❖ Эрх бүхий албан тушаалтнуудад тавигдах шалгуур тогтоох, залгамж халааны бодлоготой болох
- ❖ Тайлангийн жил дууссаны дараа ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгдөг болох
- ❖ Хороод ТУЗ-д үйл ажиллагаагаа тогтмол тайлагнадаг болох
- ❖ Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хөндлөнгийн аудиторын төлөөллөөс оролцуулан, хувьцаа эзэмшигчдийг асуулт асууж мэдээлэл авах нөхцөлөөр хангадаг болох
- ❖ Жилийн үйл ажиллагааны тайланд компанид учирч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллийг тусгадаг болох

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



М.Сэлэнгэ

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:

ТУЗ-ийн дарга



Д.Гэрэлмаа

2017 оны 12-р сар